



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 506

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Гаалийн ерөнхий газрын харьяа Улаанбаатар хот дахь гаалийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 59,500,000.00 (тавин есөн сая таван зуун мянган) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий Соната-7 маркийн автомашиныг хавсралтад заасны дагуу Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Гаалийн ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Отнонжаргал, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Ням-Эрдэнэ нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Автомашины ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох асуудлыг шийдвэрлүүлж, автомашиныг автотээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс шилжүүлэн арга хэмжээний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132006140
27-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 10 дугаар сарын 19 өдрийн
506 дугаар тогтоолын хавсралт



Гаалийн ерөнхий газрын харьяа Улаанбаатар хот дахь гаалийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо ширхэг	Нийт балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Соната-7 суудлын автомашин, улсын дугаар 90-89 УБҮ, арлын дугаар КМННВ41АВЕА617817	5/20/2014	1	59,500,000.00	59,500,000.00	-
	Нийт дүн		1	59,500,000.00 (тавин есөн сая таван зуун мянга)	59,500,000.00 (тавин есөн сая таван зуун мянга)	